

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд доор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт, тайлбар тус тус нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалт:

“4.1.20”суурь тэтгэвэр” гэж өндөр насны тэтгэвэр авагчийн орлогын наад захын баталгааг хангах зорилгоор түүний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тооцож, улсын төсөв болон тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг.”

2/7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсэг:

“7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан хэд хэдэн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол зөвхөн эхний гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлнө.”

3/7 дугаар зүйлийн 7.12 дахь хэсэг:

“7.12.Энэ хуулийн 7.2, 7.3, 7.4-т заасны дагуу албан журмаар даатгуулагч өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй.”

4/7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсэг:

“7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, коллеж, дээд сургууль, их сургуульд мэргэжлийн болон техникийн, дэд бакалаврын, бакалаврын хөтөлбөрийн 15-24 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.”

5/7 дугаар зүйлийн 7.14 дэх хэсэг:

“7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-д заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 27 насанд хүрэхээс өмнө өөрөө нөхөн төлж болно.”

6/7 дугаар зүйлийн 7.15 дахь хэсэг:

“7.15.Даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, шимтгэл төлөлтийн хэмжээг Нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.”

7/13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт:

“13.1.5.Аймаг, нийслэлийн үнэт цаас.”

8/19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг:

“19.5. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь энэ хуулийн 19.4.1, 19.4.2-т заасан сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээтэй тэнцүү байна.”

9/19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэг:

“19.6.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.”

10/24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалт:

“24.1.6.энэ хуулийн 7.14-т заасны дагуу энэ хуулийн 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулсан бол.”

11/29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын тайлбар:

“Тайлбар:Энэ хуулийн 29.3.1-д заасан тэтгэврийн нөөц санд бүрдүүлэх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нь албан журмын даатгуулагчийн хувьд 2026 онд ажил олгогчийн төлөх 0.5 хувь, даатгуулагчийн төлөх 0.5 хувь, нийт 1.0 хувь, 2027 онд ажил олгогчийн төлөх 1.0 хувь, даатгуулагчийн төлөх 1.0 хувь, нийт 2.0 хувь, 2028 онд ажил олгогчийн төлөх 1.5 хувь, даатгуулагчийн төлөх 1.5 хувь, нийт 3.0 хувь, 2029 он ба түүнээс хойш ажил олгогчийн төлөх 2.0 хувь, даатгуулагчийн төлөх 2.0 хувь, нийт 4.0 хувь байна.”

- Тэтгэврийн нөөц санд бүрдүүлэх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нь сайн дураар даатгуулагчийн хувьд 2026 онд 1.0 хувь, 2027 онд 2.0 хувь, 2028 онд 3.0 хувь, 2029 он ба түүнээс хойш 4.0 хувь байна.”

11/37 дугаар зүйлийн 37.17 дахь хэсэг:

“37.17.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийг бүртгэх, нийгмийн даатгалийн шимтгэл төлөлтийн тайлан хүлээж авах, нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах, хяналт шалгалт хийх харилцааг нийгмийн даатгалын байгууллага нь татварын албатай хамтран хэрэгжүүлж болно.”

12/37 дугаар зүйлийн 37.18 дахь хэсэг:

“37.18.Энэ хуулийн 37.17-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.”

13/46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсэг:

“46.4.1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө төрсөн даатгуулагчийн 2024, 2025 онд тэтгэврийн нөөц санд байршуулсан хөрөнгийг хүүгийн хамт 2026 оны 1 дүгээр улиралд багтаан тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлнэ.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “энэ хуулийн 18.1-д” гэсний өмнө “1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг, 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:

“19.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг доор дурдсанаар тогтооно:

19.4.1.энэ хуулийн 7.4.10-т зааснаас бусад албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

19.4.2.энэ хуулийн 7.4.10-т заасан даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

19.4.3.сайн дураар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар.”

2/24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг:

“24.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх харилцааг зохицуулсан журам, энэ хуулийн 7.15-д заасан гэрээний загварыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3/29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг:

“29.5.Тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулна.”

4/37 дугаар зүйлийн 37.11 дэх хэсэг:

“37.11.Энэ хуулийн 37.10-т заасан салбар нэгжийн даргыг тухайн улсад ажиллаж байгаа нийгмийн хамгааллын төвийн дарга томилж, чөлөөлнө.”

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн “хуулийн 5.1.1-д заасан” гэснийг “хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.2, 37 дугаар зүйлийн 37.14.2 дахь заалтын “нийслэлийн” гэснийг “дүүргийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ баганын 3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.0, 1.5” гэж, 4.Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5” гэснийг “0.6” гэж, Шимтгэлийн дүн “10.5, 11.5, 12.5” гэснийг “10.4, 11.1, 11.6” гэж, 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “1” гэснийг “2” гэж, “2” гэснийг “4” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.5, 37.6, 37.8, 38 дугаар зүйлийн 38.5, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 10 дугаар зүйлийн 10.1.5, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, 21 дүгээр зүйлийн 31, 29 дүгээр зүйлийн 29.5.1, 29.5.2, 37 дугаар зүйлийн 37.9, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ